## НИЙСЛЭЛИЙН 2024 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(Хяналт шалгалтын газар)

2024 оны 12 дугаар сарын 12

Улаанбаатар хот

| Д/д | Бодлогын үндэслэл | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Санхүү-жилт сая төгрөг | Хариуцагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 203 | АХ-5.2.14, 9.4.2 НХТЖҮЧ-5.1 | Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулах | Хувь | 2022 | - | НТ 200.0 | **ХСХГ,** хяналтын чиг үүрэг бүхий бусад байгууллагууд | Барилга, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, төрийн бус байгууллага, олон нийтийн хамтын хяналтын тогтолцоог бэхжүүлэх, хяналт шалгалтын давхардлыг арилгаж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулах” ажлын хэсгийг Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төслийг боловсруулсан. Хөтөлбөрийн төслийг нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/1005 дугаартай албан бичгээр хүргүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулахаар танилцуулга, холбогдох шийдвэрийн төслийг хянуулж байна. | 90% |
| 297 | АХ-9.3.1, НХТЖҮЧ-9.3.3, | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн системийг бүрэн | Хувь | 2022 | 30 | НТ 150.0 | **ХСХГ** | -Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаа, шинэчлэлтийг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах талаар | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НЗДҮАХ-6.1.3 | ашиглалтад оруулах /барилга, байгууламжийн хяналт эрсдэлийн удирдлагын дэд системтэй/<br>-Дэд систем ашиглалтад оруулах ажлын хэрэгжилт | | | | | | Хот байгуулалт, хотын стандартын газар, Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар болон холбогдох байгууллагуудын хамтарсан 2 удаагийн уулзалтад оролцож, хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн хооронд холболт хийгдэхэд өгөгдөл, мэдээллүүдийн урсгалыг тодорхойлох үүднээс ашиглалтад орсон барилгын мэдээллийн сангийн бүрдэл, хэрэглээний талаар мэдээлэл боловсруулж 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Нийслэл Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.<br>-Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээр барилга барих хүсэлтээ гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахимжуулахаас гадна инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх ажлын үйл ажиллагааг цахимжуулж иргэн, хуулийн этгээд шийдвэрлэлтийн явцыг харах, хянах боломжтой болсон. Дээрх системд барилга барих зөвшөөрлийн хүсэлт-10210, эдээлэл бүртгэгдсэн барилга, байгууламж-23114, шугам сүлжээний зурган мэдээлэл-34730, тохижилт, ногоон байгууламжийн зурган мэдээлэл-12364, нийгмийн дэд бүтцийн зурган мэдээлэл-1906 бүртгэгдсэн ба хяналт шалгалтын ажилд нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 332 | АХ-9.2.34, 9.3.8, МУХТЖҮЧ-2.5.2, 2.5.6, 9.3.1 МУЗГҮАХ-3.7.12, НХТЖҮЧ-9.14.1, НЗДУБХЗҮАХ-6.3.20 | Улаанбаатар хотын өндөржилтийн зураглалын баримт бичгийг хот төлөвлөлт, байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөх, гүйцэтгэлд нэгдсэн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах | Хувь | 2023 | - | - | УБЗАА, ХБХГ, **ХСХГ,** НЗХГ, НБОГ, НГЗБА Төвийн 6 дүүрэг | Улаанбаатар хотын өндөржилтийн зураглалын баримт бичгийн гүйцэтгэлд Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн дагуу Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын геодези зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагч хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хяналт шалгалтын газарт дээрх чиглэлийн байцаагч байхгүй болно. | - |
| **Биелэлтийн дундаж үнэлгээ** | | | | | | | | | **90%** |

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.МӨНХБАЯР

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХТУЯА

НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА